



МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН,  
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2014 оны 01 сарын 27 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.6.2 дахь заалт, тус газрын Даргын зөвлөлийн 2014 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 1 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Тус хөтөлбөрийн үндсэн чиглэлийн дагуу төлөвлөгөө гарган, тодорхой арга хэмжээ авч ажиллахыг хөтөлбөрт оролцогч байгууллагуудын дарга, захирал нарт даалгасугай.

Гурав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахыг Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /Б.Алтансүх/, хэрэгжилтэд жил бүр хяналт, шинжилгээ хийж ажиллахыг Хяналт шинжилгээний газар /Б.Мөнхтулга/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЖАДАМБАА

110381

Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны  
газрын даргын 2014 оны 07 сарын 27 өдрийн  
26 дугаар тушаалын хавсралт

**МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ, ШУУДАН, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЛБАРЫН  
ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖ  
БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТАН, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ  
ХӨТӨЛБӨР**

**Нэг. Хөтөлбөрийн зорилго**

1.1. Хөтөлбөрийн зорилго нь Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны салбарын төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгууллагын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад оршино.

**Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим, хэрэгжүүлэх хугацаа**

2.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зарчим:

2.1.1. Монгол улсын хууль тогтоомжийн хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх

2.1.2. Ил тод, нээлттэй байх

2.1.3. Бодитой байх

2.2. Хөтөлбөрийн үе шат:

2.2.1. Нэгдүгээр үе шат: 2014-2015 он

2.2.2. Хоёрдугаар үе шат: 2015-2016 он

2.3. Хөтөлбөрийг Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газрын Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар нь бусад төрийн болон төрийн бус байгууллага, банк, санхүүгийн байгууллагатай хамтран төлөвлөгөө гарган хэрэгжилтийг зохион байгуулна.

**Гурав. Хөтөлбөрийн үндсэн чиглэл**

3.1. Хөтөлбөр дараах үндсэн чиглэлтэй байна.

3.1.1. Ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах,

3.1.2. Ажилтан, албан хаагчдын орон сууцны нөхцлийг сайжруулах,

3.1.3. Орон сууц, хашаа байшин худалдан авах, шинээр барих, нөхцөл сайжруулах, зуслангийн байр барихад нь холбогдох хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлэх,

3.1.4. Хөдөө орон нутагт ажиллагсадын ажиллах нөхцлийг дээшлүүлэх,

3.1.5. Ажилтан, албан хаагчдыг ажлын үр дүнг харгалзан шагнал, урамшууллын тогтолцоог нэвтрүүлэх,

3.1.6. Ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хангахтай холбогдсон тодорхой арга хэмжээг тухай бүр хэрэгжүүлэх,

3.1.7. Ажилтан, албан хаагчдад, цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нөхөх төлбөр, тусламж олгох,

3.1.8. Ажилтан, албан хаагчдыг сурах, мэргэшлээ дээшлүүлэхэд дэмжих,

3.1.9. Ажилтан, албан хаагчдын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх арга хэмжээ авах,

3.1.10. Ажилтан, албан хаагчдын эрүүл мэнд, чийрэгжүүлэлтийн асуудалд анхаарал хандуулах,

3.1.11. Ажилтан, албан хаагчдын хөдөө орон нутаг болон гадаад улсад томилолтоор ажиллах хугацаанд амь нас, эрүүл мэндийн даатгалд хамруулах

3.2. Хөтөлбөрийн дээрх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, арга хэмжээ боловсруулан ажиллана.

#### Дөрөв. Хөтөлбөрийн санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгө дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

4.1.1. Жил бүрийн төсөвт тусгах

4.1.2. Төсвийн хэмнэлт

4.1.3. Зээл, тусламж

4.1.4. Бусад

#### Тав. Хөтөлбөрийн оролцогчид

5.1. Хөтөлбөр дараах оролцогч байгууллагатай байна:

5.1.1. Мэдээллийн технологи, шуудан харилцаа холбооны газар

5.1.2. Харилцаа холбооны зохицуулах хороо

5.1.3. Мэдээлэл холбооны сүлжээ төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани

5.1.4. Монголын цахилгаан холбоо хувьцаат компани

5.1.5. Монгол шуудан төрийн өмчит хувьцаат компани

5.1.6. Радио телевизийн сүлжээ улсын төсөвт үйлдвэрийн газар

5.1.7. Мэдээлэл технологийн үндэсний парк

5.1.8. Үндэсний Дата төв улсын төсөвт үйлдвэрийн газар

----- оОо -----